

Монгол дахь хүн ам зүйн сургалт судалгаа

Д. Ганхуяг

Монгол Улсын Их Сургуулийн Хүн Ам

Зүйн Сургалт Судалгааны Төвийн дэд захирал

1980-аад оны үеэс дэлхий нийтэд хүн амын асуудлын хөгжлийн үйл явц дахь ач холбогдлыг өндрөөр үнэлэх болсон. 18-р зуунд Мальтусын гарган тавьсан хүн амын өсөлт ба нөөцийн хүрэлцээний талаарх онолыг энэ үеэс анхааралтай судлан улс орнууд өөрийн онцлогыг харгалзан үзэж, бодлогын чиглэлд тусгах болжээ. Өөрөөр хэлбэл аливаа хөгжлийн стратегид хүн амын өсөлт, экологийн тэнцвэрт байдал, технологи, нөөц ашиглалтын асуудлуудыг бүхэлд нь авч үзэх шаардлага тавигдсан. Эндээс хүн амын хязгааргүй хэрэгцээг нөөцийн хязгаарлагдмал түвшнээр хэрхэн хангах вэ гэдэг нь хөгжлийн төлөвлөлтийн гол зангилаа асуудал болж байна.

Орчин үеийн дэлхийн нийтлэг чиг хандлагын дагуу ардчилсан засаг төрийн эрхэм үүрэг нь тухайн улс орны, үндэстний эрх ашгийн хамгаалах, ард түмний сайн сайхан байдлыг бүхий л талаар хангахад чиглэгдэх ёстой. Энэ үүргийн хүрээнд тухайн нийгэмд тулгамдсан, эмзэг, бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх, арилгах, ядаж боломжит доод түвшинд хүртэл багасгах явдал зайлшгүй багтана. Энэ зорилтыг хангахын тулд төр засгаас хууль тогтоомж гаргах, бодлого боловсруулах, тэдгээрийг оновчтой хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаагаа явуулдаг. Эцсийн эцэст улс орны нийгэм-эдийн засгийн бүхий л асуудлууд хүн рүү чиглэсэн, хандсан, түүнтэй нөхцөлдсөн байдаг. Нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлсийн харилцан үйлчлэл чиглэл, хир хэмжээ нь шууд болон шууд бус олон хамааралтай байдаг нарийн түвэгтэй, цогц үзэгдэл тул удирдлага, бизнес, хувь хүний түвшинд шийдвэр гаргахдаа эдгээрийг салангид авч үзэх бололцоогүй билээ.

Аливаа хууль тогтоомж, түүний заалт болгоны цаана түүнийг хэрэгжүүлэх механизм арга зам нь тодорхойлогдсон байх ёстой. Эс тэгвээс хэрэгжүүлэх арга замыг нь зааж өгөөгүй хууль тогтоомж, бодлого хөтөлбөр нь зөвхөн тунхаглалын шинжтэй баримт бичиг болно. Иймд аливаа асуудлыг шийдвэрлэх механизмыг тодорхойлохын тулд тухайн асуудлын мөн чанар, шинж байдал, үүсэн гарах шалтгаан, үр дагавар, хамрах хүрээ зэргийг зайлшгүй гарган тавьсан байх хэрэгтэй. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих нь төрийн хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагуудын үндсэн үүрэг функцэд, харин холбогдох асуудлыг тодорхойлж судлах, шинжилж дүгнэлт хийх нь судалгаа шинжилгээний байгууллагуудад хамаарагддаг юм.

НҮБ-аас хүн ам зүйн асуудлыг онцгой анхааран 1969 онд Хүн Амын Санг байгуулан дэлхийн олон оронд өргөн хүрээтэй үйл ажиллагааг явуулж байна. Олон улын дээд хэмжээний 3 чуулга уулзалт зохион байгуулсан бөгөөд 1994 онд Каир хотноо хуралдсан Хүн ам Хөгжил сэдэвт хурлаас баталсан Үйл Ажиллагааны Хөтөлбөрт тогтвортой хөгжил гэдэг нь эдийн засгийн үйл ажиллагааны, тухайлбал аж үйлдвэр, эрчим хүч, хөдөө аж ахуй, дэд бүтэц зэрэг бүх салбарт үйлдвэрлэл ба хэрэглээг удаан хугацаанд

тогтвортой болгож, байгалийн нөөцийг экологид ээлтэйг, хүн амд хүртээмжтэйгээр ашиглах оновчтой арга ажиллагаа гэж тодорхойлсон. Мөн дээрх хөтөлбөрт хүн ам ба хөгжлийн уялдаа холбоог хангах талаар засгийн газруудад доорхи зөвлөмжийг гаргасан. Үүнд:

– Тогтвортой хөгжилтэй холбогдсон бүх бодлого, хөтөлбөрүүдийг олон улсын, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн хэмжээнд боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх ажилд хүн амын асуудлыг уялдуулсан байх хэрэгтэй. Хүн ам зүйн үйл явцын богино, дунд, урт хугацааны нөлөөлөл, мөн тэдгээртэргэн тусах үр дагаврыг хөгжлийн стратегид бодитой тусгасан байх ёстой.

– Эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн бодлого хөтөлбөрүүдийн хариуцдаг байгууллагуудын шийдвэр гаргах, хэрэгжүүлэх бүх шатанд хүн амын хүчин зүйлийг зохих ёсоор авч үзэх явдлыг хангахад шаардагдах дотоодын механизм ба таатай орчныг буй болговол зохино.

– Хүн ам ба хөгжлийн стратегийг нэгтгэх арга замыг нийтийн боловсрол ба мэдээллийн хөтөлбөрийг сайжруулах, Засгийн газар, засгийн газрын бус байгууллагууд ба хувийн секторын хамтын ажиллагаагаар хөөрөнгө оруулалтын нэмэгдүүлэх, судалгааг өргөтгөх түүнчлэн үндэсний ба орон нутгийн чадавхийг бэхжүүлэхэд оршино.

– Тогтвортой хөгжилд хүрэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх зорилтыг хангахын тулд Засгийн газрууд үйлдвэрлэл ба хэрэглээний зохисгүй нөхцөлийг багасган арилгах, хүн ам зүйн зохистой бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авбал зохино.

Монгол улс нь эртнээс хүн ам зүйн алсын хараатай бодлого баримтлан ирсэн бөгөөд өнөөгийн түвшинд хүн ам зүйн асуудлуудыг өөрийн онцлогийг хадгалах, дэлхийн улс орнуудын жишгийг харгалзах замаар шийдвэрлэх зорилт тавьж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж буй сүүлийн жилүүдэд нийгмийн бүхий л тогтолцоонд хувьсал, өөрчлөлт гарч байгаагийн нэгэн адил хүн ам зүйн асуудлуудын хүрээнд олон шинэ нөхцөл бүрэлдээд байна. Монголын хүн ам зүйн бодлогыг цогц байдлаар томъёолон, хэрэгжүүлэх явдал Засгийн газрын анхаарлыг төвд байгаа асуудал бөгөөд үүнд хүн ам зүйн сургалт судалгааны асуудал ч хамрагдаж байна.

Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв

Хүн амын асуудлыг төрийн бодлогын түвшинд анхааран үзэх болсноор хүн ам зүйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургалт судалгааны тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага тавигдсан билээ. Энэ зорилтыг хангах үүднээс 1990 онд Засгийн Газрын 254-р тогтоолоор Монгол Улсын Их Сургуулийн харъяанд Хүн Ам Зүйн Лабораторийг байгуулсан юм. 1993 оноос НҮБ-ийн Хүн Амын Сангийн санхүүжилтийн тусламжтайгаар үйл ажиллагааных нь хүрээг тэлж, үндэсний хэмжээний хүн ам зүйн чиглэлийн сургалт судалгааны нэгж болгон өргөжүүлж, тус лабораторийг Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв хэмээн нэрлэх болсон. Тус төв нь төрийн болон олон нийтийн байгууллагууд, олон улсын

байгууллагууд, гадаадын их дээд сургуулийн холбогдох салбаруудтай өргөн хүрээний нягт хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Зорилт

Тус төв нь боловсон хүчин болон сургалтын материаллаг баазыг бүрэн хангасны үндсэн дээр шинжлэх ухааны өндөр түвшинд хүн ам зүйч, статистикч-хүн ам зүйч, эдийн засагч-хүн ам зүйч мэргэжилтнийг баклавын зэргээр бэлтгэх, хүн ам зүйч магистрантурын сургалт явуулах, үндэсний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад хүн ам зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд дахин сургалт зохион байгуулах, хүн ам нийгмийн асуудлаар өргөн хүрээний судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэн Засгийн Газрын болон бусад холбогдох байгууллагуудыг цаашдын бодлого хөтөлбөрт шаардагдах мэдээллээр хангах үндсэн зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Үндсэн сургалт

Хүний нөөцийн хөгжилтэй холбогдон, нийгэмд шаардагдаж буй хүн ам зүйч мэргэжилтнийг баклавын болон магистрын зэргээр бэлтгэн сургах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Хүн ам зүйн ангийн оюутнууд нь эдийн засгийн онол, статистик, менежмент зэрэг суурь хичээлүүдийг эхний 2 жилд үзэн судлах ба сүүлийн 2 жилд хүн ам зүйн нарийн мэргэжлийн хичээлүүдийг суралцаж байна. Мөн түүнчлэн эдийн засаг, статистик, маркетинг, улс төр судлал, сэтгүүл зүй зэрэг их сургуулийн бусад холбогдох салбарын оюутнуудад хэд хэдэн төрлийн хичээлээр үйлчилж байна. Хүн ам судлал, хүн ам зүйн шинжилгээний хичээлүүдээс гадна "Эмэгтэйчүүд, хүн ам хөгжил", "Хүн ам, хөгжлийн төлөвлөлт бодлого", "Хүн ам зүйн судалгааны арга зүй", "Монголын хүн амын асуудлууд" зэрэг хичээлүүдийг зааж байна. Оюутнуудад онолын мэдлэг олгохын зэрэгцээ тус төвөөс хэрэгжүүлж буй судалгааны төсөлт ажлуудад биечлэн оролцуулж, практик дадлага эзэмшүүлэхэд ихээхэн анхаарч ирлээ.

Богино хугацааны сургалт

Хүн ам болон нийгмийн асуудал хариуцан ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүдэд зориулан богино хугацааны эрчимт сургалт зохион байгуулах явдал нь ХАЗССТ-ийн нэг үндсэн зорилт юм. Энэ хүрээнд 1994 оноос эхлэн Эрүүл Мэндийн Яам, Хүн Амын Бодлого Хөдөлмөрийн Яам, Улсын Иргэний Бүртгэлийн Төв, Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо, Эрүүл Мэнд Нийгмийн Хамгааллын Яам зэрэг төрийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран хэд хэдэн сургалт явуулсан билээ. Цаашид энэ төрлийн сургалтыг эрчимтэй үргэлжлүүлэх, өргөжүүлэх шаардлагатай байна.

Судалгаа

Дээр дурдсанчлан хүн ам зүйн асуудлуудыг нарийвчлан судалж, мөн чанар, үр дагавар, чиг хандлагыг тодорхойлох нь макро түвшний нийгэм-эдийн засгийн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулахад чухал нөлөөтэй билээ.

ХАЗССТ анх байгуулагдсан үеэсээ судалгаа шинжилгээний чиглэлд онцгой анхаарал хандуулж ирсэн билээ. Хүн ам зүйн асуудлыг хөндсөн хэд хэдэн судалгааг Улсын Статистикын Газар, Эрүүл Мэндийн Яам, Хүн амын Бодлого Хөдөлмөрийн Яамтай хамтран хийсэн юм. 1992-1995 онд ХАБХЯ-ны захиалгаар "Монгол улсын хүн амын бодлогын шинжлэх ухааны үндэслэл" сэдэвт төсөлт ажлыг хэрэгжүүлсэн бөгөөд үр дүн нь "Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого" баримт бичигт өргөн тусгагдсан билээ. 1996 оноос Эрүүл Мэнд Нийгмийн Хамгааллын Яамны захиалгаар "Монгол улсын хүн амын өсөлт ба нийгэм-эдийн засгийн хөгжил" сэдэвт 3 жилийн төсөлт ажлыг хэрэгжүүлж байна. Мөн 1995-1996 онд Японы Фукушийн Их Сургуультай хамтран "Орон нутгийн нийгэм-эдийн засгийн асуудлууд" сэдэвт эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн.

Тус төвөөс 1994, 1996 онуудад 10 гаруй аймаг, Улаанбаатар хотыг хамруулсан хүн ам зүйн 2 удаагийн түүвэр судалгааг явуулж, үр дүнг тайлагнан, судалгааны илтгэлүүдийг гадаад дотоодын холбогдох байгууллагууд, судлаачдад хүргэсэн юм. Энэхүү судалгаанууд нь хүн ам зүйн нарийвчилсан тоо мэдээлэл цуглуулж шинжлэх, тус төвийн багш оюутнуудад судалгаа зохион байгуулах чадавхи эзэмшүүлэх, бэхжүүлэх, судалгааны үр дүнг бодлого боловсруулагчид, шийдвэр гаргах түвшний мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгч, цаашдын бодлого хөтөлбөрт тусгах зэрэг үндсэн зорилтуудыг хангахад чиглэгдэж байлаа. Мөн ЭМНХЯ, МЭХ зэрэг газруудаас зохион байгуулсан нөхөн үржихүйн чиглэлийн сургалтын үр дүнг үнэлэх 2 удаагийн судалгааг явуулж, зөвлөмж гаргасан болно.

Хүн ам зүйн асуудлуудыг хөндсөн мэргэжлийн хэвлэл үгүйлэгдэж байсан тул тус төвөөс 1996 оны 10-р сараас эхлэн "Монголын Хүн Ам Зүйн Сэтгүүл"-ийг эрхлэн гаргаж байна. Энэ сэтгүүл нь хүн ам зүй судлаачид өөрсдийн бүтээлээ хэвлэх, мэдээлэл солилцох бололцоог нээж өгч байна.

Номын сан, компьютерийн төв

Тус төвийн дэргэд хүн ам зүйн чиглэлийн номын сан ажиллах болсон бөгөөд одоогоор энд 1000 гаруй ном хэвлэл байгаагаас гадна олон улсын байгууллагууд, нэр хүндтэй их дээд сургуулиуд, судалгааны газруудаас эрхлэн гаргадаг мэргэжлийн сэтгүүлүүдийг тогтмол хүлээн авч байна. Мөн түүнчлэн компьютерийн сүлжээний ЗҮЗЛШИУ шугамаар дэлхий нийтэд хэвлэгдэж буй хүн ам зүйн ном хэвлэлүүдийн талаарх мэдээллийг шуурхай хүлээн авч, захиалах бололцоогоор хангагдсан юм.

ХАЗССТ-ийн компьютерийн төв нь орчин үеийн өндөр хүчин чадалтай техникээр тоноглогдсон. Оюутнуудад компьютерийн суурь программ хичээлүүдээс гадна, хүн ам зүйн мэргэжлийн PEOPLE, PAS, WORKERS, MORTPAK, DEMPROJ зэрэг программууд, судалгааны мэдээлэл боловсруулах SPSS, ISSA программуудыг өргөн эзэмшүүлж байна.